

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2024 оны 03 дугаар сарын 15-ны өдөр, Баасан гараг*

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-2
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	3-12

---

1. “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	3-11
2. “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	11-12

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы  
Төрийн байгуулалтын байнгын хорооны 03 дугаар сарын 15-ны өдөр  
/Баасан гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 22 минутад Төрийн ордны “Жанжсин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Батсуурь, Т.Доржханд, Ц.Мөнх-Оргил;  
Чөлөөтэй: А.Адъяасүрэн, С.Амарсайхан, Ё.Баатарбилэг, Г.Ганболд, Л.Оюун-Эрдэнэ;

**Нэг. “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, мөн хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Н.Энхболд “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар танилцуулав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, С.Бямбацогт, Б.Пүрэвдорж нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Н.Энхболд, Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Б.Пүрэвдорж нар үг хэлэв.

**Н.Энхболд:** “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 09 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

**Хоёр. “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, мөн хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Н.Энхболд “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар танилцуулав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Н.Энхболд:** “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 3  
Бүгд: 11  
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 38 минут үргэлжилж, 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр 10 цаг 00 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Н.ЭНХБОЛД

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ  
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 03 дугаар сарын 15-ны өдөр,  
Баасан гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”  
танхим,  
09 цаг 22 минут

### ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Н.Энхболд:** Ирц бүрдсэн байна.  
Бүртгэлд орсон гишүүдээ танхимдаа  
дуудчихъя, хүүхдүүд ээ.

Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц бүрдсэн байна. Ингээд энэ удаагийн Улсын Их Хурлын отгон чуулганы хугацаан дахь Төрийн байгуулалтын байнгын хорооны 3 сарын 15-ны өдрийн анхны хуралдаан нээснийг мэдэгдье.

Алх маань хаачсан юм бол.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлаа танилцуулъя. Өнөөдөр 2 асуудал хэлэлцэнэ.

Төрийн байгуулалтын байнгын хорооны 24 оны 3 сарын 15-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Хуралдаанаар хэлэлцэх асуудал 2 байна.

“Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг товлон зарлаж, санал авах өдрийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл,

Мөн “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 24 оны ээлжит сонгуульд техник, хэрэгсэл хэрэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Асуудлаа батлаад оръё.

Ажлын хэсгийн гишүүдийг оруулаарай. Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанд Сонгуулийн ерөнхий хорооны дарга Дэлгэрнаран, Сонгуулийн ерөнхий хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Бат-Эрдэнэ нар оролцож байна.

“Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 24 оны ээлжит сонгуулийг товлон зарлах тухай, санал авах өдрийг тогтоох тухай” Их Хурлын тогтоолын төслийг эхлээд хэлэлцье.

Дэгтэй холбоотой зохицуулалтууд Орон нутгийн сонгууль товлон зарлах тухай хууль тогтоомж дотор Монгол Улсын Их Хурал орон нутгийн хурлын ээлжит сонгуулийг сонгуулийн жилийн 5 сарын 01-ний өдрөөс өмнө товлон зарлаж, санал авах өдрийг тогтооно. Орон нутгийн хурлын ээлжит сонгуулийн санал авах өдөр нь ээлжит сонгуулийн жилийн 10 дугаар сарын эхний хагасын аль нэг ажлын өдөр байна гэж заасан. Ингээд Улсын Их Хурал шийдвэр гаргахаар хууль тогтоомжид заасан болон хууль хэрэгжүүлэхтэй холбогдсон аливаа зохион байгуулалтын шинжтэй асуудлын талаар хариуцсан байгууллага, эрх бүхий албан тушаалтан саналаа ирүүлсэн бол холбогдох Байнгын хороо хуралдаанаараа хэлэлцэж, санал, дүгнэлтээ шийдвэрийн төслийн хамт нэгдсэн хуралдаанд оруулна гэсэн зохицуулалттай.

Сонгуулийн ерөнхий хорооноос 3 сарын 04-ний өдөр 1-118 тоот бичгээр сонгууль товлон зарлах тухай санал ирүүлсэн. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д Монгол Улсын Их Хурал орон нутгийн хурлын ээлжит сонгуулийг сонгуулийн жилийн 5 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө товлон зарлаж, санал

авах өдрийг тогтооно. 9.2-т Орон нутгийн хурлын ээлжит сонгуулийн санал авах өдөр нь ээлжит сонгуулийн жилийн 10 сарын эхний хагасын аль нэг ажлын өдөр байна гэж тус тус хуучилсан.

Иймд аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг товлон зарлах, санал авах өдрийг тогтоох болон Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д заасны дагуу сонгуулийн автоматжуулсан системийг сонгуульд хэрэглэх зэрэг асуудлыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэж өгөхийг хүсье гэсэн Дэлгэрнаран даргаас гарын үсэгтэй Сонгуулийн ерөнхий хорооны бичиг ирсэн байгаа.

*Би төслөө танилцуулчихъя.*

Монгол Улсын Их Хурлын тогтоол. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийг 2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэхээр товлон зарласугай.

2. Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн санал авах өдрийг 2024 оны 10 сарын одоогийн байдлаар 11 гээд тавиад явж байгаа, тэгээд хэдүүлээ ярилцаагаая. 11-ний өдөр байхаар тогтоосугай.

3. Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн ийм тогтоолын төсөл бэлдсэн, танилцуулж байна.

*Төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байвал нэрээ өгчихье.*

Ер нь урьд өмнөх сонгуулиудаас харахад гол төлөв тухайн жилийнхээ 10 дугаар сарын эхний хагасын сүүлчийн Баасан гарагт хийж байсан ийм шийдвэрүүд гарч байсан юм билээ. Тэгж бодоод Байнгын хорооноос бид нар 10 сарын, энэ удаа 10 сарын 11 гээд тавьсан байгаа. Үүнтэй өдөр дээр санал, байр суурь илэрхийлэх хүн байвал сонсоцгооё.

*Сүхбаатар гишүүн асууя.*

**Ж.Сүхбаатар:** Гишүүдийнхээ энэ хаврын ээлжит чуулганы энэ өдрийн мэндийг хүргэе. Яах вэ, ер нь олон жил яригдаж байсан энэ орон нутгийн сонгуулийн санал авах өдрийн нэг асуудал байдаг. Зүгээр тэр маань энэ Сонгуулийн ерөнхий хорооныхон маань хэр санал гомдол авдаг юм бол. Тухайлах юм бол манай Дархан, Сэлэнгийн район гэдэг юм уу, Төв аймаг гэдэг юм уу нөгөө тариаланчид, ногоочид ихтэй ийм аймгуудын тухайд яг нөгөө тариа ногоогоо хөөцөлдөөд хураах гээд ингээд явж байх үед нь ихэвчлэн таарчхаад байдаг юм. Лав л манай Дарханы Хонгор, Орхон сум эд нар дээр хүртэл ингээд л ядаж байхад нөгөө орон нутгийн сонгууль болж байгаа өдөр ажилтай гээд л явчихсан хүмүүс жишээлбэл ингээд л байдаг байсан байхгүй юу. Тэгээд л дандаа л нэг тийм байдал таарчхаад байдаг. Тэгэхээр энэ асуудал дээр ер нь зүгээр сүүлийн жилүүдэд хэр онцлог санал онол гарч байсан юм бол? Хуучин хэвээрээ байна уу? 10 дугаар сарын 11-ний өдөр гэдэг бол яг л бас л нэг тэр үе таараад байдаг юм. Тэгээд энэ дээр бас өдөр судрыг нь бас тал дээр санал онол юу байна гэдгийг 1 дүгээрт асууя.

2 дугаарт, яах вэ, бас энэ удаа Улсын Их Хурлын сонгуулийн энэ бүрэн эрхийн хугацааны сүүлийн энэ хаврын ээлжит чуулган бас явж байна. Зүгээр энэ юун дээр хэлэхэд манайхан орон нутгийн сонгуулийг бас хамт явуулъя гэж дандаа ярьдаг байсан. Тэгэхээр зарим бас иргэдийн тухайд ингээд сонирхоод харж байдаг. Тэгэхээр энэ бол орон нутгийн сонгууль женеерал лекшин буюу бүх нийтийн сонгууль биш учраас яг тэр парламентын сонгуультай хамтатгаад бүрэн ингээд явуулаад, мөнгө төгрөг хэмнэнэ гэдэг буруу байдаг юм шүү. Би үүнийг дараагийн энэ ирэх сонгуульд нэр дэвшихгүй учраас бас зарим хүмүүст хандаж бас хэлмээр байгаа юм.

2008-аас 12 онд Сонгуулийн хуулийг хийчхээд эргээд сонгогдоод ороод ирсэн чинь чинь сонгуулийн хуулиа өөрчлөөд муутгачихсан байсан шүү дээ. Түүн шиг энэ орон нутгийн сонгуулиа устгачхав гэдэг үүднээсээ бас энэ Сонгуулийн ерөнхий хорооныхонд хэлэхэд орон нутгийн гэсэн үгтэй шүү. Тэгэхээр зарим бүс нутгийн чанартай орон нутгийн зарим аймгийн сонгууль л Их Хурлын парламентын сонгуультай давхар явж болохоос биш нийтээрээ явж болохгүй. Тэгэх юм бол орон нутгийн биш бүх нийтийн сонгуулийн хавсарга болж хувирдаг нэг ийм юутай гэдгийг бас таширамд бас хэлье гэж бодож байна.

**Н.Энхболд:** Баярлалаа. Сонгуулийн ерөнхий хороо яг өдрийн талаар түрүүчийн 2 сонгууль яг аль аль өдрүүдэд явсан байна. Түүнийг нэг хэлээд, энэ удаад яг та нарын зүгээс тодорхой санал байна уу гэж асууж байна.

Бид нар бол яг хуулиар заачихсан, хязгаартай. Ерөөсөө 10 сарын эхний 15 хоногийн аль нэг ажлын өдөр л гэж байгаа.

Дэлгэрнараран дарга 3 номерын микрофон өгье.

**П.Дэлгэрнараран:** Сүхбаатар гишүүний асуултад хариулъя. Хуульд нэгэнт 10 сарын эхний 15 хоногийн аль нэг ажлын өдөр гэж заасан учраас яг өдөр дээр энэ 15 хоног дотроо аль нэг ажлын өдөр дээр бид нарт тодорхой санал алга. Аль нь ч болохоор байна. 11-ний өдөр бол 5 дахь өдөр Баасан гараг байгаа. Тэгэхээр Баасан гарагт зохион байгуулахад урьд нь зохион байгуулахад энэ бол яах вэ, ер нь түрүүний яригддаг төвөгшил байсан. Гэхдээ 10 дугаар сар луугаа гараад ирэхээр зэрэг хадлан тэжээлийн асуудал арай цэгцэрдэг. Тэгээд бас яах вэ, газар тариалангийн асуудал ачаалалтай байдаг хэвээрээ. Тэгээд яах вэ, ер нь аль ч юмыг нь бүгдийг нь тэгш зохицуулна гэхэд бас хугацааны хувьд хэцүү л дээ. Тэгээд 10 сарын 11-ний өдөр гэхэд бид нарт болж байна гэж үзэж байна. Өөр санал байхгүй. 20 оны ...

**Н.Энхболд:** Дэлгэрнараран дарга аа, сүүлийн 2 сонгуулиар хэд дэх өдрүүдэд явж байв. Аль гарагуудад явж байж.

**П.Дэлгэрнараран:** 20 оны орон нутгийн сонгууль 10 дугаар сарын 15-ны өдөр бас Баасан гарагт таарч байсан байгаа юм. Тэгэхээр энэ 4 дэх өдөр таарч байсан. Тэгээд энэ 15-ны өдөртөө явахад урд талын сонгуулиуд бол яг л энэ хугацаанд жишгээрээ явж байсан. Тийм.

**Н.Энхболд:** Сүхбаатар гишүүн бас санал хэлсэн. Түүнийг Сонгуулийн ерөнхий хороо цаашидаа бас аливаа асуудал яахдаа та анхаарч байна биз, тийм ээ.

Бямбацогт гишүүн асууя.

**С.Бямбацогт:** Гишүүдийнхээ өглөөний амгаланг айлтгая. Чуулган завсарласан энэ хугацаанд бас тойрогтоо ажилласан. Орон нутгийн иргэдтэй бас уулзалтууд хийсэн. Бүсчилсэн хөгжлийн бодлого, бүсчилж сонгууль явах талаар бас ард иргэдтэй санал бодлоо солилцож иргэдийн саналыг

сонссон. Ингээд явж байхад үндсэндээ бүсчилсэн хөгжлийн бодлогыг дэмжиж байна. Бүсчилж бас сонгууль явуулахыг бас дэмжиж байна. Улсын Их Хурлын гишүүд сум, аймаг ярьдаггүй, жалга дов ярьдаггүй, улс орны хэмжээний том бодлого ярьдаг, бүс нутгийн хөгжлийн асуудал ярьдаг болж байгааг дэмжиж байна. Яг үүнтэй адилхан Орон нутгийн сонгуулийг бас баг багаасаа сонгогддог хэдхэн ах дүү нараа цуглуулаад сонгогдчихдог энэ байдлыг халж болохгүй юу. Сумынхаа иргэдээс, нийт иргэдээсээ сумын иргэдийн хурлын төлөөлөгч сонгодог ийм зарчим руу оруулж болохгүй. Ингэж бас сум орон нутгийн бодлого ярьдаг болгомоор байна. Тэгэхгүй ах дүү нарын нэг багийн бодлого ярьдаг энэ асуудлыг халмаар байна, ингэж л бас энэ чинь сум, орон нутаг хөгжинө өө гэсэн асуудал их ярьж байна л даа.

Тийм болохоор Орон нутгийн сонгуулийн хуульдаа өөрчлөлт оруулаад энэ иргэдийн яриад байгаа энэ асуудлыг бас тусгах бололцоо боломж юу байдаг юм бол? Бид нар Их Хурлын сонгуулийн хуульдаа өөрчлөлт хийгээд үндсэндээ бас сонгуулийн нэлээн ахицтай өөрчлөлтүүд хийсэн. Сонгуулийн зардлуудыг бууруулах тухайлах юм бол ухуулагч нарын тоо буурч байгаа, ухуулгат ашигладаг машины хэмжээ, машины тоо хэмжээ бас буурч байгаа. Нөгөө ухуулгын самбар, хэвлэл, материал бас буурч байгаа. Мөн бас жендерийн тэгш байдлыг хангах талаар бас тодорхой бас ахиц дэвшил гарсан. Нэг иймэрхүү өөрчлөлтүүдийг бас Орон нутгийн сонгуулийн хуульд бас хийж болохгүй юу? Одоо ярих юм бол Орон нутгийн сонгуулийн хуульд чинь нөгөө жендер бас 20-оор аль нэг хүйсийнх нь төлөөлөл 20-оос доошгүй хувь гээд бас бага байж байгаа. Их Хурлын сонгуулийн хуульд бид нар 30-аас доошгүй хувь байх ёстой, 28-40-өөс доошгүй хувь болгоно гээд оруулчихсан байж байгаа. Гадаадын иргэдийг бас санал өгөх бололцоо боломжийг хангасан байж байгаа. Нийгмийн бас төлөөллийн

сонгогдох бас бололцоо боломжийг бий болгосон байж байгаа.

Ийм байдлаар Их Хурлын сонгуулийн хуульд бас нэмэлт сайжирсан өөрчлөлтүүд орсон. Эдгээрийг тусгаад мөн бас орон нутгийн иргэдээ бас өөрсдийнх нь ярьж байгаа нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага бэхжүүлэх, сум, орон нутгаас хөгжих илүү юу гэдэг юм багийн түвшинд биш, ах дүү нарын түвшинд биш, асуудлаа бас томоор нь харах бололцоо боломжийг бий болгох. Энэ чиглэлд нь Орон нутгийн сонгуулийн тухай хуулиа бас өөрчлөөд, сайжруулаад, иргэдийн хүсэл сонирхол тийм үү, тавьж байгаа санал бодлыг тусгаад ингээд явах бололцоо боломж юу байна. Энэ дээр бас ярилцаад уг нь хийчихвэл зүгээр байх юм.

Улсын Их Хурлын сонгуулийн хуулийг бид нар Үндсэн хуульд нэг жилээс хугацаанаас өмнө өөрчлөх гээд Үндсэн хуульд заачихсан. Орон нутгийн сонгуулийн тухай хуулийг орон нутгийн сонгуулийн хуульд бас жилийн өмнө гээд заачихсан байж байгаа. Гэхдээ уг нь зайлшгүй, бас ингээд нийгмийн шаардлага байна. Өшөө сайжрах тийм үү, иргэдийн хүсэл бодол байна. Өшөө хууль маань сайжраад илүү бас улс орон хөгжих, сум, орон нутаг хөгжих бололцоо боломж ийм байдлаар бас бий болох гээд байгаа. Тэгээд энэ рүү нь чиглүүлээд нэмэлт, өөрчлөлтөө хийчих зохицуулалт, боломжууд юу байгаа бол. Энэ дээр нэг тодорхой бас хариулт өгөөч. Энэ бол иргэдийн өөрсдийнх нь хүсээд байгаа хүсэл сонирхол. Тэр сонгогчдын. Бид бас орон нутгийн сонгуулиа бас сайжруулмаар байна. Улсын Их Хурлын сонгууль бүсчилж явж байгаа чинь сайн байна. Зөв болж байна. Үүнтэй адилхан Орон нутгийн сонгуулийг ч гэсэн бас нэг жоохон томруулаад хийчихмээр байна гэдгийг иргэд яриад байна л даа.

**Н.Энхболд:** Манайхан түүхээ сайн мэдэж байгаа. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт орсон. Үүний дагуу бид

нар Улсын Их Хурлын тухай, Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиуддаа, Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт орсон байгаа. Түүн дотор сая Бямбацогт гишүүний хэлсэн олон жил яригдсан дэвшилттэй асуудлыг илүү сайн боловсронгуй болгосон нэлээд олон зүйлүүд орсон. Яг үүнийгээ баримтлаад бид нар Орон нутгийн сонгуулийн тухай хуулийг өөрчлөөд, төсвийг нь боловсруулаад Улсын Их Хурлаар нэлээн тал талаас нь яриад, саяын яг Бямбацогт гишүүний яриад байгаа зүйлүүдийг тодорхой хэмжээгээр тусгаад, хуулийн төслөө бэлдээд, чуулганд өргөн мэдүүлээд, хэлэлцээд үндсэндээ бүгдээрээ тохироод, эцсийн хэлэлцүүлгээрээ бүгд дэмжээд ганцхан алга цохиж санал хураах асуудал үлдсэн байсан. Харамсалтай нь яг 10 сарын 30-ны өдөр шиг санаж байна. 2 дахиж тэр асуудлаар санал хураах гэж бэлдээд, зохион байгуулаад, ирц бүрдэж чадалгүй байж байгаад тэр өдөр өнгөрсөн. Ингээд тэр өдөр өнгөрсөн учраас нэг жилийн дотор одоогийн хүчин төгөлдөр мөрдөж байгаа Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 82.1-д Орон нутгийн хурлын ээлжит сонгуулийн санал авах өдрөөс өмнө нэг жилийн хугацаанд Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно гэсэн заалттай. Заалтыг бариад одоо бид нар саяын яг өнөөдөр Бямбацогт гишүүний хэлж байгаа тэр өөрчлөлтийг оруулах ийм боломж байхгүй байна.

Тэр бэлдээд, тэр бэлдээд энэ дээр адилхан органик хууль бол тэгнэ, ингэнэ гэсэн юм байхгүй л дээ. Тийм. Тэр хууль дээр бид нар ингэж оруулсан байхгүй юу. Нэг жилийн өмнө биш 6 сарын өмнө өөрчлөлт оруулж болохгүй гээд өөрөөр хэлбэл дахиад үлдэж байгаа 6 сарын хугацаанд нь яг саяын юмнуудаа яриад нэмээд оруулъя гэж бодоод хуулиа хийчихсэн байсан. Харамсалтай нь тэгээд баталж чадаагүй. Одоо хэрэв бид

нар энэ хуулиа үүнийг 82.1-ийг зөрчөөд хууль баталбал хууль зөрчсөн хэрэгт орчих гээд ингээд боломжгүй болчихоод байгаа юм. Түүнээс бүгдээрээ үндсэндээ уг нь яг Бямбацогт гишүүний сая ярьж байгаа зүйлүүдийг дэмжсэн юм. Тэгээд харамсалтай нь тэр ирц бүрдээгүй. Би бол жоохон бүрдүүлээгүй юм болов уу гэж бодоод байгаа юм. Яагаад гэвэл дотор нь бас нэг ганц нэг зарим санал зөрөлдсөн зүйлүүд байсан. Тухайлбал сумын хурал, аймгийн хурал 2-т аль нэгэнд нь л дэвшинэ гэсэн. Одоо бол аль алинд нь дэвшиж болж байгаа шүү дээ. Гэх мэтчилэн ийм зүйлүүдээс болоод ирцийг бүрдүүлээгүй юм болов уу гэж би зүгээр бодож байгаа. Энэ миний хувийн бодол.

Тэгээд харамсалтай нь тэр боломж өнгөрсөн алдагдсан байгаа.

Пүрэвдорж гишүүн асууя.

**Б.Пүрэвдорж:** Хөдөө орон нутгаар 78 сумтай, манай тойрог. Тэрний 67 орчмоор орон явчхаад ирлээ. Тэгээд үүгээр иргэдтэй уулзаж байхад энэ бүсчилсэн тойргийн Их Хурлын сонгуулийн энэ асуудлыг хүмүүс дэмжиж байна. Яагаад гэвэл олон олон аймагт ажил хийдэггүй Их Хурлын гишүүд олон байсан байна. Тийм учраас тэд нарыгаа бас шүүмжилж байна.

2 дугаарт нь, энэ бүсчилсэн тойрог бол ер нь Монголын хөгжилд хэрэгтэй юм байна гэж олон хүн ярьж байна. Тэгээд энэ дотроо үүнийг дэмжингээ бид нар бас яах юм бэ гэдэг асуудлыг ярьж байна л даа. Бид нар энэ сумаа нэг тойрог болгоод, тэндээ илүү тэр нэг хамаатан садны хамаарлаас гаргаж, мэдлэг боловсролтой хүмүүс нь тэр сумаасаа бүгдээрээ танигддаг. Тэр хүмүүс нь сонгогдоод тэгээд илүү сумаа хөгжжүүлье гэсэн ийм эрмэлзэл тэр хүмүүст байна.

2 дугаарт нь, тэр аймгийн төлөөлөгчөө яаж сонгох вэ? Түүн дээр



бас тодорхой хэмжээгээр бүсчилбэл зүгээр байна энэ тэр гээд ийм ийм олон олон саналуудыг гаргаж байна. Тэгэхээр энэ дээр 6 сарын өмнө дахиад хуулиа өргөн бариад батлуулах бүрэн боломжтой. Энэ бол Үндсэн хууль зөрчихгүй асуудал байхгүй юу даа. Өөрөөр хэлбэл урьд нь бидний баталсан Орон нутгийн сонгуулийн хуулийг одоо шинээр батлах Орон нутгийн сонгуулийн хуулиар өөрчилж болно. Энэ нээлттэй. Энэ Үндсэн хуулийн зөрчил рүү ерөөсөө явахгүй. Тийм учраас энэ дээр, дээрээс нь юу байдаг юм, нэг баахан хүмүүс л одоо 6 сарын өмнө ажлаасаа гардаг. Нэг багш, эмч, тэгээд л тэр хүмүүс чинь ажлаасаа гар юу байя уу. Тийм ээ. Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд сонгогд юу байв уу. Тэгээд ингээд нэг баахан сар ажилгүй байх дээр гэр орон цалин цаваа байхгүй тэр чинь, сум чинь нэг өрх бүлийн чинь 2 хүний нэг нь л ажилтай байгаа. Тэд нар нь тэгээд цалингүй болчихоор тэдний орлого хэцүүдчихдэг, ийм зүйл байгаад байгаа юм. Тэгэхээр энэ бид нар дахиад шинэ хууль оруулж ирэх юм бол ядаж тэр хүмүүсийг 9 сарын 1-нд чөлөөлөөд тийм ээ, тэгээд 10 сард нь сонгуульд нь оруулчихаад тэгээд буцаагаад ажилд нь томилоод тэр хүмүүсийн орлогыг нь алдуулахгүй байх ийм зүйлүүдийг бид нар бас энэ хуулиараа хиймээр байна л даа. Тэгж байж бид нар энэ илүү сайн мэргэжилтэй боловсон хүчнийг энэ орон нутгийнхаа иргэдийн төлөөлөгч сонгосны үр дүнд бас энэ сум, орон нутаг хөгжих ийм боломжийг бий болгоно л гэж би харж байгаа.

Тэгэхээр энэ органик хуулиар нэг хуулийг өөрчилж болох эрх мэдэл нь өнөөдөр Их Хурал дээр байгаа учраас энэ хуулийг хурдан өргөн бариад энэ асуудлыг цэгцлэх хэрэгтэй. Иргэдийн хүсэлт тийм байна. Тийм учраас энэ, энэ бол Энхболд даргын өгч байгаа энэ тайлбар ер нь хуучин сонгуулийн хуулиараа оръё л гэсэн ийм л цааргалалт байна л гэж би харж байна.

Тийм учраас энэ Улсын Их Хурлынхаа сонгуулийг болохоор ингээд иргэд яаж байна гэхээр өөрсдөдөө зориулаад аль болох дахин сонгогдох тэр юмнуудыг л хийгээд байна гэж иргэд хараад байна. Тэгээд энэ нь бас яах вэ, бас дахиад хөгжил авчирна гэж бас иргэд бас харж байна. Тэгэхээр энэ хөгжил чинь бас бид нар дээр ирэх ёстой, бид нарын юмыг хуульчлах шийдвэр болохоор ингээд бас хойшоо суугаад, цааргалаад байх юм гэдэг ийм л зүйл ард ... /минут дуусав/

**Н.Энхболд:** Үндсэндээ сая яг Бямбацогт гишүүнтэй адилхан асуулт, адилхан санал дэвшүүлж байна. Тэгээд ингэж би нэг их цааргалаад байгаа юм байхгүй л дээ. Яг одоо байгаа хуулийн дагуу ингэх ёстой юм. Энэ хугацаанд хийх ёстой. Тэгэхээр ингэж болно, зүгээр ямар ч байсан бид нар өнөөдөр хурлынхаа товыг зарлаад, техник хэрэгсэл хэрэглэх зөвшөөрлөө өнөөдөр гаргачих хэрэгтэй. 6 сарын өмнө байна уу, жилийн өмнө байна уу энэ 10 сард л явж таарна. 6 сар үнэхээр Үндсэн хууль зөрчих асуудал гарахгүй гэж үзэж байгаа бол тэгж үзэж байгаа гишүүд яаралтай өргөн мэдүүлээд, 6 сарын өмнө өөрчлөлт оруулахыг хориглоно гэсэн хууль гаргаж чадвал, тэгвэл саяын юмнуудыг бас оруулах боломж гарч магадгүй. Түүнийг би урьдчилж хэлж мэдэхгүй байна. Гэхдээ ямар ч байсан одоо бол бид нар өнөөдрийнхөө хүчин төгөлдөр байгаа хуулийн хүрээнд өдрөө товлоод, техник хэрэгсэл ашиглах шийдвэрээ гаргачихсан байх нь зөв.

Цаад асуудал нь нээлттэй үлдэж байгаа. Тийм. Тэгээд би түрүүн бас хэлсэн. Тийм, тэгээд би түрүүн бас анзаарсан байх та нар ирц бүрдсэн үү, бүрдүүлээгүй юу гэдэг бол тэр үед их сонин асуудал болоод өнгөрчихсэн юм байгаа юм. Бүх юм бэлэн болчихсон хойно. Тэгэхээр би дахиад ийм Байнгын хорооны даргын цааргалалттай холбоотой огт хамаагүй асуудал шүү. Тэгж яривал тэр үед тодорхой хэсэг

хүмүүс бас хуралд орж ирэхгүй байж байгаад хурлаа хойшлуулаад, тэгээд энэ асуудлыг өөрчлөх боломжийг алдагдуулчихсан юм гэдгийг л хэлье. Би маш идэвхтэй тэр хуулийг өөрчлөх асуудлыг маш идэвхтэй эсэргүүцээд явж байсан. Нэр ус дурдаад нэг их яах гээд шаардлага алга л даа. Тийм, тэгээд яах вэ дээ мэдэж байгаа бол өөрөө тэгээд хараад авчих, тийм. Тэгэхээр одоо бол хэдүүлээ хүчин төгөлдөр хуулийнхаа дагуу ямар ч байсан өдрөө тиймээ, техникийнхээ юмтай тогтоогоод ингээд явчихъя. Тэгээд дараагийнхаа асуудлыг яах нь гишүүдэд эрх мэдэл нь нээлттэй байж байгаа. Тэгээд тэр тусмаа тэр яг тэр үед эсэргүүцээд байсан хүмүүстээ сайн ойлгуулаад явбал, юмыг яаж мэдэх вэ боломж гарах ч юм билүү гэж бодож байна.

Гишүүд асуулт асууж, санал хэлж дууслаа, үндсэндээ.

Одоо тогтоолоороо саналаа хураая.

Би одоо хэлсэн хүн болгон саналаа хэлчихээр нь санал хэлчихсэн юм байх гэж бодоод. Дэгээр бол санал хэлэх боломж байгаа. Санал, үг хэлэх гишүүд нэрээ өгье.

Тогтохсүрэн, Пүрэвдорж.  
Тогтохсүрэн гишүүн.

**Д.Тогтохсүрэн:** Баярлалаа. Тогтоолын төслийг дэмжиж байна. Энэ 10 сарын 11 гэдэг өдрийг. 4 сарын 30-наас эхэлж зарлаж байгаа юм байна. Бид чинь хуулийн хүрээнд нь Их Хурал 6 сарын өмнө шийдвэрээ гаргах ёстой. Тийм учраас шийдвэрээ гаргаад явах нь зөв байх гэж бодож байна. Зүгээр, би яг энэ асуудалтай холбоогүй. Гэхдээ сонгуультай холбоотой 2 асуудлыг хэлье гэж бодож байна.

Төрийн байгуулалтын байнгын хороо Энхболд дарга аа, ойрын үед энэ Улсын Их Хурлын сонгуулийн бэлтгэл

ажилтай холбоотой асуудлаар Сонгуулийн ерөнхий хорооны нэг мэдээллийг нэг сонсчихмоор байгаа юм. Өмнө нь ч чиглэл өгсөн Төрийн байгуулалтын байнгын хорооноос. Нөгөө бид чинь томсгосон тойргоор явж олон мандаттай байна гэж бодоогүйгээр нөгөө сонгуулийнхаа хуулийг батлаад, зардлыг нь батлаад өгчихсэн юм. Тэгээд энэ нөгөө 9, 10 мандаттай тойргуудтай болчихсонтой холбоотойгоор зардал нэмэгдэж байгаа. Хэсгийн хороодын тоо нэмэгдэж байгаа. Санал өгдөг кабины тоо нэмэгдэж байгаа. Тоног төхөөрөмжүүд нэмэгдэж байгаатай холбоотойгоор зардал болон бусад зохион байгуулалттай холбоотой асуудлууд байгаа юм. Тийм учраас би Төрийн байгуулалтын байнгын хорооны хурлаар ойрын үед ирэх 7 хоногт Сонгуулийн ерөнхий хорооны мэдээллийг нь нэг сайн сонсоод, тэгээд тэр гаргасан асуудлаар нь нэг тогтоол гаргаад, Байнгын хорооны тогтоолоор Засгийн газарт нэг чиглэл өгөөд нэг зардлын асуудлыг нь шийдээд, бэлтгэлийг нь нэг бүрэн хангаад явуулчих асуудал байгаад байгаа юм.

2 дахь асуудал нь энэ Идэрбат нарын гишүүд санаачилчихсан байх ёстой доо, өргөн барьж байгаа болов уу. Энэ орон нутгийн сонгуулийн хуульд, сонгууль дараагийн орон нутгийн сонгууль явагдаад дууссаны дараа дараагийн бүрэн эрх эхлэхэд нутаг дэвсгэрийн нэгжийн хууль дээр шийдчихсэн байх шаардлагатай 3 асуудал байгаа юм.

1 дүгээрт нь, Багийн иргэдийн Нийтийн Хурлын, 1 дүгээрт нь Багийн Засаг даргыг дэд боловсролтой байна гээд заачихсан юм. Тэгэхээр манай хөдөөгийн нөгөө Багийн дарга нар чинь энэ шаардлагыг хангаж чадахгүй байгаад байгаа юм. Тэгэхээр энэ заалтыг хойшлуулах уу, аль эсвэл хүчингүй болгох уу гэдэг асуудал байгаа юм. Тийм. Одоо ажиллаж байгаа хүмүүсээ тэгээд цаашидаа боловсролоор нь бүгдийг

гаргаад хаячих уу гэдэг асуудал байгаад байгаа байхгүй юу.

2 дугаарт нь, бид нар Багийн иргэдийн Нийтийн Хурлын даргыг хуралдааны дарга болгочихсон юм. Үүнийг орон нутгаас тавьж байгаа нэг гол санал бол Хурлын дарга болгож өгөөч гээд байнга тэгээд байгаа юм. Тийм. Тийм учраас энэ асуудлуудтай холбогдуулаад бас бид нар өмнө нь ч Их Хурлын гишүүд ярилцаад энэ Идэрбат гишүүнээр ахлуулаад манай нэг ажлын хэсэг ажиллаж байгаа. Эд нар маань хуулиа бэлэн болгочихсон байгаа. Үүнийг болж өгвөл хаврын чуулганаар хэлэлцээд баталчихвал орон нутгийнханд хэрэгтэй юм байгаа юм. Сая энэ Пүрэвдорж гишүүн, Бямбацогт гишүүн нар яриад байгаа асуудал бол энэ орон нутгийн иргэдэд нь хэрэгтэй ийм том асуудал байгаа. Энэ нь нутаг дэвсгэрийн нэгжийн хуулиар шийдчих ёстой юм байгаа юм.

Түрүүн тэр Пүрэвдорж гишүүн яриад байна лээ. Орон нутгийн сонгуулийн хууль одоо бол хаагдчихсан л даа. Сөхөж ярихаар аягүй хэцүү л дээ. Яагаад гэвэл хуульд нь өөрийнх нь хуульд тусчихсан байхгүй юу. Нэг жилийг хөндөхгүй гээд. Хэдий Үндсэн хуульгүй ч гэсэн.

Нөгөө талаас нь төрийн албан хаагчдын хувьд 8 сарын 01 гэдгийг бид нар 20 оноос тавьчихсан байхгүй юу. Тийм учраас 6 сарын өмнө, жилийн өмнө эд нар байхгүй, 8 сарын 01-нээс байгаа учраас 2 сарын өмнө ажлаасаа гараад, бэлтгэлээ хангаад явах бололцоо бүрэн байж байгаа.

**Н.Энхболд:** Санал сонслоо. Ер нь ярьж байгаа. Яг таны саяын ярьсан зүйлийг. Ялангуяа тэр 2 дахь асуудалтай холбоотой талаар бид нар яг энэ чиглэл дээр нэлээн ажилласан. Төрийн төрийн бус байгууллагууд, нийслэлийн удирдлагын бүрэлдэхүүнтэй уулзаж ярилцаад үүнийг ямар нэг байдлаар шийдэх хэрэгтэй юм байна гэдгийг

ярьсан байгаа. Тэр сонсгол авъя. Дэлгэрнаран дарга аа, бэлдэж байгаарай. Энэ ойрын үед бас сонгуулийн бэлтгэлийн талаар танайхаас нэг мэдээлэл аваадахъя. Санал байвал түүн дээрээ тогтоолын төсөлд ийм зүйлүүд баймаар байна гээд оруулаад ирвэл бас болж байна. Бид нар тэгээд ярья.

Пүрэвдорж гишүүн санал.

**Б.Пүрэвдорж:** Улсын Их Хурлын сонгуулийг 5 дахь өдөр зохион байгуулахаар болсон. Түүнтэй адилхан Орон нутгийн сонгуулийг 1 дэх өдөр зохион байгуулахаар орж ирж байна, дахиад 5 дахь өдөр. тийм. Тэгэхээр энэ бол залуучуудыг сонгуульд оролцуулахгүй байх өөрөөр хэлбэл залуучууд их өөрчлөлтийг хүсэж байдаг. Тийм учраас энэ яаж ч мэдэх санал өгөгч нар учраас эд нарыг оруулахгүй байх л үндсэн аргыг хийж байна гэсэн үг гэж би хэлж байсан. Их Хурлын сонгуулийн хууль дээр. Тэгэхээр яах вэ гэхээр 4 дэх өдрийн орой гарч давхиад, нэг ойрхон нөгөө хамаатан садандаа, аав ээждээ очъё гээд гараад давхичихна, амралт зугаалгад явна гээд гараад давхичихна. 5 дахь өдөр залуучууд сонгуульд оролцохгүй, тэгээд хагас сайн, бүтэн сайнд, 5 дахь өдөртөө ингээд 3, 4 өдөр яваад ирье гээд ингээд л залуучууд сонгуульд орохгүй байх л ийм л юмыг манай Монгол Ардын нам сэдээд хийгээд байгаа л даа. Тэгээд энэ бол, бид нар тэртээ тэргүй энэ Монголыг яаж ч муутгаж байсан, яаж ч хөгжүүлэхгүй байсан, энэ улс орныг доройтуулсан ч, утаа униарыг гаргаж байсан ч, авлига хээл хахуулийг гааруулж байсан ч, бид нарыг дэмждэг тэртээ тэргүй бид нарт хайртай ахмад гишүүд маань байгаа. Тэд нарынхаа санал дээр гарна гэдэг ийм л үндсэн бодлого дээр энэ сонгуулийн өдрийг товлоод байгаа юм. Тэгээд би үүнд маш их харамсаж байгаа юм. Тэгээд 11-ний өдөр болгоно гэж орж ирж байна. Тэгээд өөрсдөө болохоор 11-ний өдөр гэж санал орж ирсэн л дээ. Тэгэхээр өөрсдөө болохоор өдөр судраа маш сайхан судалж байгаад л тийм ээ,

Дашням Балжиннямтай өдөр Улсын Их Хурлын сонгуулиа хийчхээд, тэгээд 11-ний өдөр модон хохимой өдөр орон нутгийнхаа сонгуулийг хийнэ гээд л. Тэгээд л энэ уулаасаа нөгөө нэг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар энэ орон нутгийн, нутгийн өөрөө удирдах ёсны эрх мэдлийг маш их булааж авсан, 10 гаруй зүйлээр булааж авсан. Өнөөдөр тэрний үр хорыг Монголчууд эдлээд сууж байна. Тэр багийн иргэдээс санал авч, ашигт малтмалын лиценз олгодог байсан тэр байдал хэн нэгэн Ашигт малтмалын газрын гарын үсгээр л олгодог байсан байна. Тийм ч учраас манай МоАХ-ынхон энэ газар нутгаа тоолъё гэдэг аяныг өрнүүлээд явж байна. Нутгийнх нь эзэд нутгийнхаа эзэн болж чадаагүй байна шүү дээ. Ийм л юм болоод байгаа юм. Тэгээд ингээд аль болох л энэ нутгийн өөрөө удирдах ёсыг л байхгүй болгох л сонгуулийг хүртэл модон хохимой өдөр зарлана гээд л орж ирдэг. Ийм л байдлыг болих хэрэгтэй шүү.

**Н.Энхболд:** Шинийн 8-ны өдөр юм байна лээ. Дашням, Балжинням яривал бас тийм, шинийн 8-ны өдөр чинь сайн өдөр л байдаг л даа. Ингээд саналаа, саналаа, би өөрөө саналаа ярьж байна, тийм.

Хэрэв Пүрэвдорж гишүүн маань ярьж байна, би санал нэг байна. Залуучууд энэ төрийнхөө сонгуульд оролцъё, маш их хүсэл эрмэлзэлтэй байгаа. Үнэхээр тийм хүсэл эрмэлзэлтэй байгаа хүмүүс 5 дахь байна уу, 2 дахь байна уу, бүтэн сайн байна уу ирээд сонгуульдаа орно гэж би бодож байгаа. Үнэхээр залуучууд маань тийм байгаа. Ямар ч өдөр байсан төрийн ажилдаа оролцоно оо гэдэгт итгэж байна. Түүнээс хөгшин, залуугаар нь ялгасан зүйл байхгүй ээ.

Саналаа хураая. Түрүүн тогтоолын төсөл танилцуулсан. 4 сарын 30-наас эхлэхээр сонгуулиа зарлаж

байна. 10 сарын 11-ний өдөр санал авах өдөр байхаар тогтоолд тусгасан. Төсөл уншиж танилцуулсан. Тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Санал хураалт. Санал хураалт, гишүүд ээ.

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 7 нь дэмжиж, 63,6-аар санал дэмжигдлээ.

Тогтоолын төслийг чуулганы хуралдаанд би өөрөө танилцуулчихна.

1 дүгээр асуудал дууслаа.

09.58 цаг.

2 дахь асуудалдаа оръё. Гялалзуулчихъя, хэдүүлээ.

2 дугаар асуудал.

**Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 24 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай тогтоолын төслөө танилцуулчихъя.**

Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн сонгогчдын бүртгэлийн үйл ажиллагаанд бүртгэлийн техник хэрэгслийг санал авах, тоолох, дүн гаргах үйл ажиллагаанд Нью имиж каст санал тоолох төхөөрөмжийг хэрэглэхийг зөвшөөрсүгэй.

Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Төсөл танилцууллаа.

*Асуух гишүүн байна уу? Алга байна.*

*Үг хэлэх гишүүн байна уу? Алга байна.*

*Тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт.*

*Санал хураалтад 11 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжиж, 72,7 хувиар санал дэмжигдлээ.*

*Тогтоолын танилцуулга, дүгнэлтийг Жаргалмаа гишүүн чуулганы нэгдсэн хуралдаанд.*

*Байнгын хороогоор хэлэлцэх асуудал дууслаа.*

*Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаан дууслаа.*

*10.00 цаг*

*Баярлалаа, гишүүддээ.*

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ*

*П.ОЮУНГЭРЭЛ*